

СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ (бүтэн жил)

1.АНХАН ШАТНЫ СУРГАЛТ

Шинэ албан хаагчдад зориулсан дотоод орчны танилцуулах сургалт	Тухай бүр	Шинээр ажилд орсон 132 албан хаагчид танилцуулах сургалтыг улиралд 1 удаа зохион байгуулж ажилласан. Энэхүү сургалтаар театрын ерөнхий танилцуулга, театрын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлог, дотоодод мөрдөгдөж байгаа дүрэм журмуудыг танилцуулсан.
Театрын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм журмын шинэчлэл, өөрчлөлтийн тухай сургалт	Тухай бүр	2024 оны 6 дугаар сарын 09, 10 дугаар сарын 25-ны өдрүүдэд албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, театрын Ёс зүйн дүрэм, УБ театрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын онцлог, өөрчлөлтүүдийн талаар сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 159 албан хаагчийг хамруулж ажилласан.
Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын тухай сургалт	Улиралд 1 удаа	Театрын ёс зүйн дэд хорооноос албан хаагчдад зориулсан ёс зүй, сахилга хариуцлагын талаарх сургалтыг улиралд 1 удаа зохион байгуулж ажиллалаа. Ёс зүйн дэд хорооны гишүүд 1-р улиралд дуу ангийн 19 албан хаагчийг, 2-р улиралд хөгжим ангийн 25 албан хаагчийг, 3-р улиралд бүжигч ангийн 16 албан хаагчийг, 4-р улиралд тайз, захиргааны 22 албан хаагчийг тус сургалтад хамруулж ажилласан.

3.АХИСАН ШАТНЫ СУРГАЛТ

Төрөл бүрийн танхимын болон цахим сургалтууд	Жилийн турш	НЗДТГ-ын дэргэдэх Хүний нөөцийн хөгжлийн төвийн төлөвлөгөөт 13 удаагийн сургалтад 68 албан хаагч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон захиргааны бусад байгууллагаас зохион байгуулсан 10 удаагийн сургалтад 18 албан хаагч, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг Пүрэв гарагийн вебинар 4 удаагийн сургалтад цахим хэлбэрээр 16 албан хаагчийг хамруулсан.
Архив, албан хэрэг хөтлөлтийн ахисан түвшний сургалт	III улиралд	2024 оны 5-р сард “Монгол бичгээр баримт бичгийг зохион бүрдүүлэх” сургалт - Захиргааны ахлах мэргэжилтэн Б.Түмэндэлгэр, Хүний нөөцийн менежер Л.Одгэрэл, Архив, бичиг хэргийн эрхлэгч Б.Сувд-Эрдэнэ, Дотоод ажил, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн Л.Цолмончимэг нарыг, 11-р сард “Албан хэрэг хөтлөлтийн “eDoc” системийн ашиглалт, баримт боловсруулах, шийдвэрлэх, хяналт тавих тухай” сургалтад шинээр ажилд томилогдсон Дотоод ажил, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн С.Ёндон, ХАБЭА хариуцсан мэргэжилтэн Б.Бүрэнжаргал нар хамрагдсан.

2.ДУНД ШАТНЫ СУРГАЛТ

Бакалавр, доктор, магистрын түвшинд албан хаагчдыг хамруулах.	5-6 албан хаагч	Бакалавр, магистр, докторын чиглэлээр мэргэжлийн сургуульд элсэн суралцаж байгаа албан хаагчдад суралцах нөхцөлийг хангаж, ажлын цагийн уян хатан зохицуулалтыг хийж, ажлын ачааллыг тэнцвэржүүлж ажилласан. Магистрын түвшний сургалтад Гоцлол дуучин Т.Баянжаргал, Дуучин Г.Жаргалмаа, Х.Хонгор нар суралцаж байгаа бол бакалаврын түвшний сургалтад дуучин Г.Найдандоо, хөгжимчин Г.Амартүвшин, Ц.Амина, А.Нинжболор, бүжигчин Н.Өгөдэй нар суралцаж байна.
Мэргэжил олгох сургалтад хамруулах, дэмжлэг үзүүлэх.	1-2 албан хаагч	Мэргэжилт олгох сургалтад Гэрэлтүүлэгч Ц.Базархааныг “ХАБЭА” ХХК-ийн “Өргөх, буулгах механизмын сургалт”-д хамруулж машинистын мэргэжил эзэмшүүлснээр тайзны машинистын албан тушаалд томилон ажиллуулж эхлээд байна. Шинэ мэргэжлээр ажиллаж байгаа ажилтан ХАБЭА хариуцсан мэргэжилтэн Б.Бүрэнжаргал өдөр бүр зааварчилгаа өгч ажилласан.
Хөтөлбөрт сургалтад бөөнөөр хамруулах.	1-2 удаа	Монголын Урлагийн Зөвлөлтэй хамтран “Моушин Монголиа” наадмыг 2024 оны 6-р сард “Моушин Монголиа” олон улсын орчин үеийн бүжгийн наадам, бүжиг дэглээчдэд зориулсан лекц, мастерклассыг зохион байгуулж, мастеркласс-д театрын бүжгийн багш Д.Баярт, Гоцлол бүжигчин Б.Норовбанзад, Бүжигчин Ж.Номгонмаа, З.Энхжаргал, П.Энхтогтох нарын 5 албан хаагчийг хамруулан олон орны бүжигчидтэй хамтран суралцаж, туршлага солилцлоо.

4.ЕРӨНХИЙ СУРГАЛТ

Аюулгүй орчин, эрсдэлгүй ажлын байр	II улиралд	Эрсдэлгүй ажлын байр сэдвээр тайз, техникийн ажилчдад зориулсан сургалтыг сар бүр тогтмол зохион байгуулж, арга зүйгээр хангаж ажиллаж хэвшсэн.
Гамшгаас хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга зүйн сургалт	IY улиралд	Ажлын байранд эрсдлийн анхан шатны үнэлгээ хийж шаардлагатай зүйлсийг гаргаж, албан шаардлага хүргүүлэв. Эрсдэлтэй ажлын байранд ажилладаг 3 албан хаагчийг 5 дугаар сард хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн эрсдэлтэй ажлын байранд ажиллах сертификаттай сургалтанд хамруулсан.

"Өөрчлөлтийн менежмент" сургалт	IY улиралд	НЗДТГ-ын дэргэдэх Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Өөрчлөлтийн менежмент" сургалтад 2024 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Д.Түвшинцогт, Ж.Буянтогтох нарыг хамруулж, тус сургалтаас авсан шинэлэг мэдээллээ тайз үйлдвэрлэлийн 10 албан хаагч, дуу ангийн 16 албан хаагчид хүргэж ажилласан.
Төрийн албан хаагчийн манлайллын сургалт	жилд 1 удаа	НЗДТГ-ын дэргэдэх Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Австралийн ТАФЭ академийн нутагшуулах сургалтын 1,2-р модуль болох "Ажлын байрны үр дүнтэй харилцааг удирдан манлайлах нь", "Сэтгэл хөдлөлийн чадамжийг хөгжүүлэн ашиглах нь" сэдэвт 2 сургалтад 20 албан хаагчаа хамруулж сертификатжуулсан. (2024.02.28)

- Модераторууд:
- ХАБЭА хариуцсан мэргэжилтэн
- Хүний нөөцийн менежер
- ДАТМ хариуцсан мэргэжилтэн
- Хүний нөөцийн менежер

12/27/2024

Хүний нөөцийн менежер

Л.Одгэрэл